



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/418

Улаанбаатар хот

Коронавируст (ковид-19) халдварын
дархлаажуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр
авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Коронавируст халдвар (ковид-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” А/33 дугаар тушаал, Эрүүл мэндийн яамны 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 1а/5434 дугаар албан бичиг, Дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 20 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн хэмжээнд Коронавируст (ковид-19) халдвараас сэргийлэх нэмэлт дархлаажуулалтын арга хэмжээг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулсугай.

2. Коронавируст (ковид-19) халдвараас сэргийлэх нэмэлт дархлаажуулалтын ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, сарын аяны удирдамжийг хоёрдугаар, зардлын төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Иргэдийг коронавирuсын халдвараас сэргийлэх нэмэлт дархлаажуулалтын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр ханган, үр дүнг тайлагнан ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (С.Мөнхзаяа), Эрүүл мэндийн төв (З.Балдандугар)-т тус тус үүрэг болгосугай.

4. Аж ахуй нэгж, байгууллагуудын хамрагдалтыг нэмэгдүүлж, холбон зуучилж, шаардлагатай мэдээллээр ханган ажиллахыг Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (Б.Бат-Өлзий)-т даалгасугай.

5. Хорооны Засаг дарга нар харьяа хорооны дархлаажуулалтанд хамрагдвал зохих иргэдийн судалгааг гаргаж, хамрагдаагүй иргэдийг дархлаажуулалтад бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Мөнгөнхуяг)-т даалгасугай.

6. Сургууль, цэцэрлэгийн багш, ажилтнуудын дархлаажуулалтад хамрагдалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Боловсролын хэлтэс (З.Энхгэрэл)-т даалгасугай.

7.Коронавируст халдвар (ковид-19)-ын нэмэлт дархлаажуулалтын ач холбогдлын талаар иргэд, олон нийтэд үнэн зөв мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, болон цахимаар сурталчилан ажиллахыг Засаг даргын зөвлөх бөгөөд Хэвлэл мэдээллийн алба (Б.Отгонбаяр)-д даалгасугай.

8.Коронавируст (ковид-19) халдварын тархалтыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах 7,500,000 (долоон сая таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Ахлах нягтлан бодогч Б.Хонгорзулд зөвшөөрсүгэй.

9.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Нарангэрэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЪЯАБААТАР



Баянгол дүүргийн Засаг даргын
2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
10 дугаар нэгдүгээр захирамжийн хавсралт

КОРОНАВИРУС ХАЛДВАР (КОВИД-19)-ААС СЭРГИЙЛЭХ НЭМЭЛТ
ДАРХЛААЖУУЛАЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтрах байгууллага
Нэг.Коронавируст халдвар (ковид-19)-аас сэргийлэх нэмэлт дархлаажуулалт				
1.	Иргэдэд зориулсан коронавируст халдвараас сэргийлэх нэмэлт дархлаажуулалтыг нэмэгдүүлэх нэг сарын аян зохион байгуулах	2021.10.25- 2021.11.25	ЭМТ	Хэлтэс, албадууд, Хороо, ӨЭМТ
2	Стратегийн өндөр ач холбогдол бүхий байгууллага аж ахуй нэгжийн 18-аас дээш насны иргэдийг вакцинжуулах	2021.10.25- 2021.10.25	ЭМТ	Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс
3	Үйл ажиллагааг тасралтгүй явуулах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллагын ажилтнуудыг вакцинжуулах	2021.10.25- 2021.11.25	ЭМТ	Мэргэжлийн хяналтын хэлтэс
4	Нутаг дэвсгэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа цэргийн анги нэгтгэлийн алба хаагчдыг вакцинжуулах	2021.10.25- 2021.11.25	ЭМТ	Мэргэжлийн хяналтын хэлтэс
5	Сургууль,цэцэрлэгийн багш, ажилчдыг дархлаажуулалтанд хамруулах	2021.10.25- 2021.11.25	Боловсролын хэлтэс	НХХ
6	Нутаг дэвсгэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа их, дээд сургуулийн багш, оюутнуудыг дархлаажуулалтанд хамруулах	2021.10.25- 2021.11.25	ЭМТ	НХХ

7	<p>Эрсдэлт бүлгийн хүн амыг вакцинжуулах</p> <ul style="list-style-type: none"> - 55-аас дээш насны өндөр настан - Архаг суурь өвчтэй хүмүүс - Дархлаа дарангуйлагдсан иргэд - Хөгжлийн бэрхшээлтэй иргэд - Эмзэг бүлгийн иргэд - Асрамжийн газар - Оршин суугаа харьяалалгүй гадаад иргэд 	2021.10.25- 2021.11.25	ЭМТ	Хороо, ӨЭМТ
Хоёр. Мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн ажил				
1	Олны танил хүмүүсээр сурталчилгаа хийлгэх	2021.10.25- 2021.11.25	Хэвлэл мэдээллийн алба	ЭМТ
2	Коронавируст халдвар (ковид-19)-аас сэргийлэх нэмэлт вакцинжуулалтын ач холбогдол, 2 дахь тун тариулснаас хойш 3 сар буюу түүнээс дээш хоносон иргэдэд чиглэсэн сурталчилгааг идэвхижүүлэх	2021.10.25- 2021.11.25	Хэвлэл мэдээллийн алба	ЭМТ
3	Цахимаар иргэдэд аяны талаар мэдээлэл хүргэх, Иргэдэд цаг тухайд мэдээлэл өгөх	2021.10.25- 2021.11.25	Хэвлэл мэдээллийн алба	ЭМТ
4	Нийт ажилтан, албан хаагчдаа дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтанд хамруулсан төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагыг сурталчилах	2021.10.25- 2021.11.25	Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс	Хороо, ЭМТ
5	Эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтын ач холбогдлын талаар цахим сурталт, мэдээлэл хийх.	2021.10.25- 2021.11.25	ЭМТ	ӨЭМТ
6	Өрхийн эрүүл мэндийн төвөөс вакцинд хамрагдах хугацаа болсон иргэдэд утсаар зөвлөгөө өгөх.	2021.10.25- 2021.11.25	ЭМТ	ӨЭМТ
7	Цахимд тандалт хийж, Түгээмэл гардаг асуулт хариулт бэлтгэн сурталчлах	2021.10.25- 2021.11.25	ЭМТ	Хэвлэл мэдээллийн алба

Баянгол дүүргийн Засаг даргын
2021 оны 10 дүгээр сарын 20-ны өдрийн
1/448 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ААС СЭРГИЙЛЭХ НЭМЭЛТ
ДАРХЛААЖУУЛАЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ САРЫН АЯНЫ УДИРДАМЖ**

2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Үндэслэл

Баянгол дүүрэг нь 235000 гаруй оршин суугчтай бөгөөд коронавируст (ковид-19) халдвараас сэргийлэх нэмэлт дархлаажуулалтанд хамрагдвал зохих 12 дээш насны 165,465 иргэд байна. Үүнээс I-тунд 160,458 иргэд буюу 96%, II- тунд -150,799 иргэд буюу 93%-ийн хамрагдалттай байна. Харин III тунгийн дархлаажуулалтанд хамрагдвал зохих 18 дээш насны 147,289 иргэдээс 31,212 иргэн буюу 21% нь хамрагдсан байна. Энэ өвчлөл нэмэгдэх шалтгааны нэг болж байна. Иймд III тунгийн хамралтыг нэмэгдүүлж, Коронавируст халдвар (ковид-19)-ын тархалтыг бууруулах зорилгоор 1 сарын аян зохион байгуулах шаардлагатай байна.

Хоёр. Зорилго

Аяны хугацаанд 25-30 мянга орчим иргэдэд коронавируст (ковид-19) халдвараас сэргийлэх нэмэлт дархлаажуулалтын III тунг хийж, хамрагдалтыг 45%-д хүргэж, өвчлөлийг бууруулах

Зорилт

1. Коронавируст халдвар (ковид-19)-аас сэргийлэх нэмэлт вакцинжуулалтын ажлыг эрчимжүүлэх,
2. Коронавируст халдвар (ковид-19)-аас сэргийлэх нэмэлт дархлаажуулалтын тухай зөв мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах,
3. Алдартай, олны танил хүмүүсээр сурталчилгаа хийлгэж, иргэдэд нөлөөлөх нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах,

Гурав. Төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтрах байгууллага
Нэг. Коронавируст халдвар (ковид-19)-аас сэргийлэх нэмэлт дархлаажуулалтыг эрчимжүүлэх				
1.	ӨЭМТ бүр өдөрт багадаа 50 иргэдэд дархлаажуулалт хийх	2021.10.22- 2021.11-25	ӨЭМТ	ЭМТ, Хэлтэс, Албадууд
2	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нийт зах, Худалдааны байгууллагуудын ажилчдыг дархлаажуулах	2021.10.25- 2021.11.25	ЭМТ-ийн явуулын баг	Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс

3	Төрийн байгууллагын ажилтнуудыг дархлаажуулах	2021.10.22-2021.11.25	ЭМТ	Мэргэжлийн хяналтын хэлтэс
4	Нутаг дэвсгэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа цэргийн анги нэгтгэлийн алба хаагчдыг дархлаажуулах	2021.10.22-2021.11.25	ЭМТ-ийн явуулын баг	Мэргэжлийн хяналтын хэлтэс
5	Оюутны дотуур байрны 18 аас дээш насны иргэдийг дархлаажуулах	2021.10.22-2021.11.25	ЭМТ-ийн явуулын баг	НХХ
6	Нутаг дэвсгэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа их, дээд сургуулийн багш, оюутнуудыг вакцинжуулах	2021.10.22-2021.11.25	ЭМТ-ийн явуулын баг	НХХ
7	Сургууль, цэцэрлэгийн багш, ажилчдыг хамруулах	2021.10.22-2021.11.25	Боловсролын хэлтэс	ЭМТ
8	Эрсдэлт бүлгийн хүн амыг вакцинжуулах <ul style="list-style-type: none"> - 55-аас дээш насны өндөр настан - Архаг суурь өвчтэй хүмүүс - Дархлаа дарангуйлагдсан иргэд - Хөгжлийн бэрхшээлтэй иргэд - Эмзэг бүлгийн иргэд - Асрамжийн газар - Оршин суугаа харъяалалгүй гадаад иргэд 	2021.10.22-2021.11.25	ЭМТ	Хороо, ӨЭМТ
Хоёр.Мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн ажил				
1	Олны танил хүмүүсээр сурталчилгаа хийлгэх	2021.10.22-2021.11.25	Хэвлэл мэдээллийн алба	ЭМТ
2	Коронавируст халдвар (ковид-19)-аас сэргийлэх нэмэлт дархлаажуулалтын ач холбогдол, 2 дахь тун тариулснаас хойш 3 сар буюу түүнээс дээш хоносон иргэдэд чиглэсэн сурталчилгааг идэвхижүүлэх	2021.10.22-2021.11.25	Хэвлэл мэдээллийн алба	ЭМТ
3	Цахимаар иргэдэд аяны талаар мэдээлэл хүргэх	2021.10.22-2021.11.25	Хэвлэл мэдээллийн алба	ЭМТ
4	Нийт ажилтан, албан хаагчдаа нэмэлт вакцинжуулалтанд хамруулсан төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагыг сурталчилж, Эрүүл	2021.10.22-2021.11.25	Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс	ЭМТ, Хороо хариуцсан мэргэжилтэн

	мэндийг дэмжигч байгууллагаар өргөмжлөх			
5	Эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтын ач холбогдлын талаар цахим сургалт, мэдээлэл хийх.	2021.10.22-2021.11.25	ЭМТ	ӨЭМТ
6	Өрхийн эрүүл мэндийн төвөөс вакцинд хамрагдах хугацаа болсон иргэдэд утсаар зөвлөгөө өгөх.	2021.10.22-2021.11.25	Хороо	ӨЭМТ
7	Цахимд тандалт хийж, Түгээмэл гардаг асуулт хариулт бэлтгэн сурталчлах	2021.10.22-2021.11.25	Хэвлэл мэдээллийн алба	ЭМТ

Дөрөв.Хугацаа

2021 оны 10 дугаар сарын 22-ноос 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл

Тав.Хүрэх үр дүн

1.Дархлаажуулалтанд хамрагдсан иргэдийн тоо нэмэгдэж, зорилгын хүрээнд төлөвлөсөн хувьд хүрсэн байна.

2.Иргэд дархлаажуулалтын ач холбогдлын талаар зөв мэдлэг мэдээлэлтэй болж, хамрагдалтын хувь цаашид өсөн нэмэгдэнэ.


3.Олны танил хүмүүсийг оролцуулж, нөлөөлөл, сурталчилгаа, мэдээлэл хийж, цахимаар болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр түгээж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлнэ.

Зургаа.Шагнал, урамшуул

1.Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтанд харьяа болон харьяаллын бус иргэд, байгууллагуудыг хамгийн ихээр хамруулсан 3 Хорооны шуурхай штабыг шалгаруулж, тус тус 2 сая төгрөгийн мөнгөн урамшуулал үзүүлэх.

2.Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтанд бүх ажилтан, ажиллагсадыг хамруулсан 5 хүртэлх байгууллага, аж ахуй нэгжийг “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-аар шалгаруулж, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр урамшуулах.

Баянгол дүүргийн Засаг даргын
2021 оны 10 дугаар сарын 20 өдрийн
1448 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



КОРОНАВИРУСТ (КОВИД-19) ХАЛДВАРЫН ДАРХЛААЖУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ
ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСВИЙН
ЗАДАРГАА

2021 оны 10 дугаар сарын 20

Улаанбаатар хот

№	Зардлын нэр	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Хорооны шуурхай штабуудад урамшуулал	3	2,000,000	6,000,000
2	Өргөмжлөл	5	25,000	125,000
3	Мананцар үүсгэгч	5	275,000	1,375,000
Нийт				7,500,000